



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 16

Арвайхээр

Сонгон шалгаруулалтын комисс томилох
тухай

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 1.4.2, 4.1, 7.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хархорин, Баруунбаян-Улаан сумдын Соёлын төвийн эрхлэгчид томилогдох ажилтныг сонгон шалгаруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулсугай.

Ахлагч: Ц.Ганболд -аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга


Нарийн бичгийн дарга: Н.Энхцэцэг -аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн

Гишүүд: Б.Мөнхжаргал -аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн

А.Отгонцэцэг -аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн

2. Сонгон шалгаруулалтыг журам, зааврын дагуу товлосон хугацаанд нь явуулж, дүнг комиссын хурлаар хэлэлцэж, сонгон шалгаруулалт явуулсан тайлан, дүн, тэнцсэн иргэдийн нэрсийн жагсаалтыг 2017 оны 07 дугаар сарын 03-ны дотор багтаан Төрийн албаны зөвлөлийн аймгийн салбар зөвлөлд танилцуулж, албажуулахыг сонгон шалгаруулалтын комисс /Б.Мөнхжаргал/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ГАНБОЛД

03 - -0031